

АРЛИНГТОН МУЖИЙН ХҮҮХДҮҮДИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АКТ

Эрсдэлтэй Залуус ба Гэр Бүлийн Цогц Үйлчилгээний Акт нь таны хүүхэд ба гэр бүлд авч буй үйлчилгээний дагуу танд зохих эрхийг олгодог.

Энэ үйл ажиллагааны байдлууд одоогийн үйлчлэх улсын хуулийн дагуу аливаа нэгэн хяналт шалгалтанд өртөхгүй (жишээ нь, тусгай боловсрол ба асрамжийн тухай хууль).

1. Та Гэр Бүлийн Үнэлгээ ба Төлөвлөгөөний Баг үнэлгээ, хувь гэр бүлийн үйлчилгээний төлөвлөгөө ба нэвтрүүлэх ажиллагааг эхлэхэд бичгээр мэдэгдэл авна.
2. Та өөрийн эх хэл дээр энэ мэдэгдэлийг авна.
3. Та хэн нэгэн хувь хүн эсвэл агентлаг энэ нууц мэдээллийг гаргахаас өмнө бичгээр зөвшөөрлөө өгнө (шүүх эсвэл хуулиар өөрөөр тогтоогоогүй бол).
4. Та Хувь Хүний Гэр Бүлийн Үйлчилгээний төлөвлөгөө хэрэгжүүлэхийн өмнө бичгээр зөвшөөрлөө өгсөн байна. (Жич: Бичгээр өгсөн зөвшөөрөл хийхэд ямар нэгэн онцгой тохиолдлууд орно).
5. Танд Хувь Хүний Гэр Бүлийн Үйлчилгээний Төлөвлөгөөний үйлчилгээг авахад хариуцагч хүн өгнө. Энэ хүнийг Хэргийн Зохицуулагч гэнэ.
6. Та эцэг эхийн хувьд Хувь Хүний Гэр Бүлийн Үйлчилгээний төлөвлөгөөнд оролцох шаардлагатай. Хэрвээ та хуваарийн дагуу болох уулзалтанд ирэх боломжгүй ба уулзалтын өмнө хэргийн зохицуулагчтай холбогдоогүй бол таныг эрхээсээ татгалзсан гэж ойлгоно. Та өөрийн гэр бүлийн гишүүн, найз, өмгөөлөгч эсвэл дэмжигч хэн нэгийг багийн уулзалтанд ирүүлж болно.
7. Та Гэр Бүлийн Үнэлгээ ба Төлөвлөгөөний Багийн шийдвэрийг дахин шалгах өргөдөл гаргаж болно. Анхны алхам бол өөрийнхөө хэргийн зохицуулагчтай холбоо барих. Хэрвээ та асуудлаар сайн ажиллах чадваргүй тохиолдолд та Олон Нийтийн Бодлого ба Зохицуулалтын Багаар томилогдсон CSA Зохицуулалтын Багт бичгээр хүсэлт гаргаж болно. Зохицуулалтын Баг нь таны хүсэлтийн хариуг бичгээр гаргах болно. Хэрвээ та Багийн шийдвэртэй санал нийлээгүй бол та Олон Нийтийн Бодлого ба Зохицуулалтын Багт өргөдөл гаргаж болно.
8. Та болон таны гэр бүлийн тухай мэдээлэл, хэрвээ та өөрөөр хүсээгүй бол, маш нууцмал байдалд байна.
9. Та өөрийнхөө бичлэгүүдийн хуулбарыг харах, хянах ба хүлээн авах эрхтэй (хуулиар өөрөөр заагаагүй бол). Та энэ бичлэгүүдийн тайлбарыг хүлээн авна.
10. Та өөрийн бодлоор буруу хийсэн, бүтэн бус, эсвэл ташаа мэдээлэл гэж үзвэл, та бичлэгийн файлд нэмэгдэх өөрийн бичгээр хийсэн мэдүүлгийг өгч болно.

Хэрвээ танд аливаа нэгэн асуулт гарвал, өөрийн хэргийн зохицуулагч эсвэл агентлагтай холбоо барина уу.